



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, "Журам батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 216 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Аргачлал, загвар батлах тухай" 100 дугаар тушаал, "Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн
дарга:

В.Батчимэг

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Ганболд

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

О.Нямбат

Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тогтоол
шийдвэрийн биелэлт хариуцсан
мэргэжилтэн

Т.Туул

Гадаад хамтын ажиллагаа хариуцсан
мэргэжилтэн

Нарийн бичгийн
дарга:

Н.Алтанзаяа

Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл
хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн

2. Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтуудтай уялдуулж холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор батлуулахыг Ажлын хэсэг (В.Батчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА *D. Batm* Д.БАТСҮХ